



Сайн сайхны төлөө бүтээв.



2023 оны эхний хагас жилийн
үйл ажиллагааны тайлан

Нэг.Компанийн ерөнхий мэдээлэл

“Хөвсгөл алтан дуулга” ХК нь 1943 онд Хөвсгөл аймгийн Тариалангийн САА-н суурин дээр үүсгэн байгуулагдсан. Тус САА нь 1994 онд өмч хувьчлалд хамрагдаж, төрийн өмч давамгайлсан Хөвсгөл алтан дуулга хувьцаат компани байгуулагдан, 1998 онд нийтийн дуудлага худалдаагаар 70,8%-ийг Тэстрейд ХХК худалдан авсанаар хувийн өмчит ХК болон зохион байгуулагдсан.

2018 онд 4.4 сая ширхэг энгийн хувьцааг (нийт хувьцааны 28%) нийтэд нээлттэй санал болгож анхдагч зах зээлд амжилттай арилжаалсан. Дүрмийн сан нь 15,734,200 ширхэг энгийн хувьцаанаас бүрддэг.

“Хөвсгөл алтан дуулга” ХК нь үр тариа тариалалт, гурил үйлдвэрлэл, тэжээл үйлдвэрлэл гэсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ба 2020 оны 4-р сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар газар тариалангийн үйлдвэрлэлийг охин компани болгон тусгаарлаж Алтан Хажир ХХК болгон зохион байгуулсан.

Нэр:	“Хөвсгөл алтан дуулга” ХК
Регистрийн дугаар:	2034565
Улсын бүртгэлийн дугаар:	1710001001
Байгуулагдсан он:	1996.04.25
Хаяг:	Хөвсгөл, Тариалан, Мандал баг
Утас:	+976-7038 6030, 7038 6055, 7711 6031
И-мэйл:	info@altanduulga.mn
Веб хуудас:	http://www.altanduulga.mn
Үйл ажиллагааны үндсэн чиглэл:	Үр тариа үйлдвэрлэл, Гурил үйлдвэрлэл, Малын тэжээлийн үйлдвэрлэл, Хүнсний ногоо тариалах, Гадаад дотоод худалдаа, Мал аж ахуй

Хоёр. Компанийн засаглал

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Компанийн ТУЗ-ийн 2023 оны 02 дугаар тогтоолд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэл ажлыг хангаж, хурлын зарыг холбогдох хууль, журмын дагуу өдөр тутмын сонин, өөрийн болон МХБ-ийн цахим хуудсаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлж, танилцах материалыг өөрийн цахим хуудсанд болон үнэт цаасны компаниудад байршууллаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 4-р сарын 28-ны өдөр 72.7 хувийн ирцтэйгээр Хөвсгөл аймаг, Тариалан сумын 1-р багт байрлах компанийн хурлын танхимд хуралдаж дараахь асуудлуудыг хэлэлцлээ.

- Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны зардлын төсвийг батлах тухай
- “Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай” ТУЗ-ийн 2023 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг танилцуулах

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа

ТУЗ нь 9 гишүүнтэй, 2023 оны 03-р сарын 15-ны өдрийн хуралдаанаар дараахь асуудлуудыг шийдвэрлэсэн байна. Үүнд:

- 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын зардлын төсөв
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай
- Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дотоод аудитын тайлан, ТУЗ-ийн дүгнэлт.

ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал

- 2023 онд ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг өмнөх оныхоос нэмэгдүүлэхгүй байхаар ХЭХ-аар шийдвэрлэсэн.

Гурав. Газар тариалангийн үйлдвэрлэл

Үр тарианы үйлдвэрлэлийг 6914 га эргэлтийн талбайд:

- 2023 онд бид 1921.5 га-д тариалалт, 1338га-д уринш хийх, 3262.6га талбай түрээслэхээр төлөвлөсөн ба өөрсдийн нөөц бололцоон дээр тулгуурлан өөрийн болон түрээсийн нийт 5321.7 га талбайд тариалалтыг амжилттай хийлээ. Өөрийн талбайд 3 өөр төрлийн агротехнологийг баримтлан тариалсан.
- Энэ жилийн газар тариалангийн үйлдвэрлэлийн зардлууд болох үр, бордоо, шатахуун, тээврийн зардлуудын өссөлттэй холбогдуулан өмнөх жилүүдтэй харьцуулахад энэ хаврын тариалалт бага талбайд хийхээр төлөвлөсөн.
- Уриншийг 779,2 га талбайд хийхээр бэлтгэл ажилдаа орсон ба 7-р сарын эхний өдрүүдэд хийж гүйцэтгэхээр төлөвлөөд байна.

2023 оны тариалалтын эцсийн мэдээ


№	Тарималын төрөл	Х.нэгж	Тариалалт		Дүн
			Уринштай S	Гуурсанд	
1	Улаанбуудай	га	1244.1	919.1	2163.2
2	Халтар арвай	га		23.1	23.1
3	Овьёос	га		66.7	66.7
4	Рапс	га		114.4	114.4
5	Ногоон тэжээл	га		93.7	93.7
6	Түрээсийн талбай	га			3043.8
	Нийт		1244.1	1217.0	5321.7

Мөн эрдэм шинжилгээ, судалгаа туршилтын талбайд ургацын тоо хэмжээ, чанарыг сайжруулахаар ХААИС-ийн 3 төрлийн туршилт судалгаа хийгдэж байна.

Дөрөв. Боловсруулах үйлдвэрлэл

Эхний хагас жилд 2022 оны ургацын чанараас хамааран үйлдвэрлэлийн цагийн хүчин чадлын 60%-ийг л ашиглаан ажилласан ба үйлдвэрлэлийн чанаржуулагч түүхий эдийн хангалтыг ХААДС-аас бүрдүүлэн ажилласан. Эхний хагас жилд нийт 2.2 мян тн буудай тээрэмдэж, 1.6 мян.тн гурил, 0.5 мян тн тэжээлийн хивэг тус тус үйлдвэрлэсэн байна.

	2022	2023
Бүхэл үр, дээд гурил	440,0	62,0
1-р гурил	2946,2	1358,0
2,3-р гурил	188,2	141,5
Хивэг	954,4	472,5



Бүтээгдхүүний чанарын хяналтын тогтолцоог сайжруулахаар гурилын үйлдвэрийн дотоод хяналтын лабораторийг итгэмжлэгдсэн лаборатори болгохоор зорин өргөтгөж, техник тоног төхөөрөмжөөр ханган, дотоод хүний нөөцийг шат дараалсан сургалтанд хамруулсанаар 4-р сард амжилттай хамгааллаа.

Тав.Санхүүгийн үйл ажиллагаа

2023 оны 6-р сарын 30-ны байдлаар Нийт актив 16,1 тэрбум төгрөг, үүнээс түүхий эд бараа материал 3,2 тэрбум төгрөг, худалдааны авлага 2,2 тэрбум төгрөг байгаа бол Төрийн банкны зээлийн үлдэгдэл 4.3 тэрбум төгрөг, бусад өр төлбөр 3,7 тэрбум төгрөг, эздийн өмч 8,1 тэрбум төгрөг байна.

Орлого, үр дүн – Нийт орлого 4,3 тэрбум төгрөг, борлуулсан барааны өртөг 3,5 тэрбум төгрөг, борлуулалт удирдлагын зардал 0,5 тэрбум төгрөг, 0.3 тэрбум төгрөгийн хүүгийн зардалтай, орлогын албан татвар 6 сая төгрөг, цэвэр ашиг 53 сая төгрөг байна.

	Сая төгрөг
ОРЛОГО, сая төг	
Борлуулалтын орлого	4,309
Бусад	
НИЙТ ОРЛОГО	4,309
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,477
НИЙТ АШИГ	832
Борлуулалт маркетингийн зардал	240
Ерөнхий удирдлагын бусад зардал	243
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ЗАРДАЛ	483
ЕРӨНХИЙ ҮЙЛ АЖ-НЫ ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ	349
Санхүүгийн зардал	290
Ердийн бус орлого зардал	
ТАТВАРЫН ӨМНӨХ ОРЛОГО	59
Татварын зардал	6
ТУХАЙН ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ	53

Өмчийн өөрчлөлтийн тайлан – Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 144 сая төгрөгөөр буурч, нийт эздийн өмч 8091,0 сая төгрөг байна.

Мөнгөн хөрөнгийн урсгал – мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 18,4 сая төгрөг, тайлант хугацааны эцэст 170,2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Банкны зээлд 308,5 сая төгрөг, татвар, шимтгэлд 110,6 сая төгрөг, түүхийн эдийн татан авалтанд 984,7 сая төгрөг, түүхийн эдийн өр төлбөрт 1093,6 сая төгрөг тус тус төлсөн байна.

Зургаа. Эрсдлийн удирдлага

МУ-ын эдийн засгийн тогтворгүй байдал, инфляци түвшин нэмэгдсэн, гадаад дотоод эдийн засаг, улс төрийн байдал, 2022 оны баруун бүс нутгийн ургац алдалт, ургацын чанар зэрэг нь компанийн үйл ажиллагаанд нөлөөлсөн ба компанийн дотоод нэгжүүдийн үйл ажиллагааг богино хугацаанд хурдтай, оновчтой шийдвэр гаргалтаар ханган ажиллахыг шаардахын зэрэгцээ нэгжүүдийн хүрээнд эрсдэлийг тодорхойлох, зэрэглэх, оновчтой үнэлж, тооцоолон гүйцэтгэлийг хянан удирдах шаардлага үүсч үүнд зорин ажиллаж байна.

Компани 2023 оны ургац хүртэл үйлдвэрлэлээ тогтвортой явуулах түүхий эдийн нөөцийг бүрдүүлж чадсан боловч түүхий эдийн чанараас хамаарч гурилын үйлдвэрлэл төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй ба үйлдвэрлэлийн үйл ажиллагаа тасалдсан нь борлуулалтанд нөлөөлсөн болно.

2023 онд үйл ажиллагааны орчин компанийн хувьд бүх талаараа хамгийн сорилттой цаг хугацаа таарч байна. Энэ нөхцөл байдалд бизнесийг тасралтгүй ажиллагааг хангахаар зорин дотоод нөөц бололцоондоо тулгуурлан хамгийн үр дүнтэйгээр ажиллахаар мэрийсээр байна.

Мөн орон нутгийн мэргэжлийн байгууллага болон мэргэжлийн боловсон хүчинтэй хамтран ажиллахыг зорин итгэмжлэгдсэн лабораторийн бэлтгэлд ажилд орон нутгаас шилдэг боловсон хүчнийг сонгон зөвлөхөөр ажиллуулсан ба ХАБЭА-н мэргэжлийн байгууллагатай хамтран байгууллагын ХАБЭА-н үнэлгээг хийлгэн цаашид хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллах эхлэлийг тавилаа.

Тайлант хугацаанд сонирхолын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй, их хэмжээний гэрээ хэлцэл хийгдсэн болно.

- ХААДС-аас 6000тн таваарын улаанбуудай худалдан авах гэрээ /2023 оны 1-р улиралд/
- ХХААХҮЯ-тай 2000тн улаанбуудай импортлох бодлогын гэрээ /2023 оны 2-р улиралд/
- ОХУ, Красноярск мужаас 2000тн таваарын улаанбуудай худалдан авах гэрээгээр /2023 оны 2-р улиралд/

Долоо. Хувьцааны арилжаа

Хувьцааны арилжаа МХБ-ийн 2-р ангилалаас арилжагдаж байгаа ба хувьцааны хаалтын ханш 2023 оны эхэнд 550 төгрөг байсан бол оны эхний хагас жилд 399.88 төгрөг болж буурсан байна.

